



## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2008 оны 10 дугаар  
сарын 22-ны  
өдөр

Дугаар 679

Улаанбаатар хот

### ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 79.7 дахь хэсэг, Улсын гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

- 1.“Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 1 дүгээр,
- “Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 2 дугаар,
- “Барааг шилжүүлэн ачих гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2.Энэ тушаалын биелэлтийг зохион байгуулж, харьяа гаалийн газар, хороодыг удирдамж чиглэлээр хангаж ажиллахыг Дэд дарга бөгөөд Хяналт, эрсдлийн удирдлагын газар/ Д. Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

3.Шинэчлэн батлагдсан гаалийн бүрдүүлэлтийн горимын кодыг ГАМАС-ийн ангилалтын санд 2008 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор оруулахыг Мэдээллийн технологийн төв /Б.Цог/-д даалгасугай.

4.Энэ тушаалыг 2009 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ДАРГА Д. ЦЭВЭЭНЖАВ**

**Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2008 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 2957 дугаарт бүртгэсэн**

Улсын гаалийн өрөнхий газрын даргын  
2008 оны 679 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## **БАРААГ УЛС ХООРОНД ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 180-187 дугаар зүйл/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.
- 1.2. Энэ журмаар горимыг сонгох, барааг горимд байршуулах, бичиг баримтыг бүрдүүлэх, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.
- 1.4. Мэдүүлэгч /тээвэрлэгч/ барааг Гаалийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан хугацаанд мэдүүлэх бөгөөд мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн ачааны манифест, мэдээлэл, бичиг баримтад энэ хугацаа мөн адил хамаарна.
- 1.5. Гаалийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан ачааны манифест, барааны дагалдах бичиг баримтыг хүлээн авч бүртгэнээр барааг гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцно.
- 1.6. ТИР карней бүхий улс хооронд дамжин өнгөрөх тээврийн хэрэгсэлд энэ журам хамаарахгүй.
- 1.7. Улсын хилээр оруулахыг хориглосон барааг энэ горимд байршуулахгүй.

### **Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код**

- 2.1. Энэ горимд хилийн чанад дахь илгээгчээс хилийн чанад дахь хүлээн авагчид илгээсэн гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх гадаадын барааг байршуулна.
- 2.2. Улс хооронд дамжуулан өнгөрүүлэхэд уг бараа нь хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.
- 2.3. Улс хооронд дамжуулан өнгөрүүлэхэд дараахь кodoор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын агуулга	Бүрдүүлэлт хийх горимын код
1	Барааг гаалийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл солихгүйгээр улс хооронд дамжуулан өнгөрүүлэх	840
2	Барааг гаалийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл сольж улс хооронд дамжуулан өнгөрүүлэх	841

- 2.4. Гаалийн бүрдүүлэлтийн горимын 840 кodoор гаалийн бүрдүүлэлт хийхэд тээврийн хэрэгсэл солихгүйгээр орох хилийн гаалийн байгууллагаас гарах хилийн гаалийн байгууллагаар шууд дамжуулан өнгөрүүлэх гадаадын бараа хамаарна.
- 2.5. Гаалийн бүрдүүлэлтийн горимын 841 кodoор гаалийн бүрдүүлэлт хийхэд тээврийн хэрэгсэл сольж, орох хилийн гаалийн хяналтын бүсээс тээврийн хэрэгсэл солих гаалийн хяналтын бүс, тээврийн хэрэгсэл солих гаалийн хяналтын бүсээс

хилийн гаалийн хяналтын бүсээр шууд дамжуулан өнгөрүүлэх гадаадын бараа хамаарна.

### **Гурав. Бичиг баримт**

3.1.Гаалийн бүрдүүлэлтийн горимын 840 кодоор гаалийн бүрдүүлэлт хийхэд электрон манифестаар гаалийн бүрдүүлэлт хийнэ.

3.2.Гаалийн бүрдүүлэлтийн горимын 841 кодоор гаалийн бүрдүүлэлт хийхэд нэг гаалийн байгууллагын хүрээнд гаалийн хяналтан дор тээврийн хэрэгсэл солих бөгөөд тухайн гаалийн байгууллага тээврийн хэрэгсэл солигдох бүрт өмнөх манифестэд хаалт хийн шинээр манифест бичиж, хэвлэн гаалийн бүрдүүлэлт хийж, дараагийн гаалийн байгууллагын хяналтад шилжүүлнэ.

3.4.Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд тээвэрлэгч байгууллага дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

3.4.1.тээврийн бичиг баримт;

3.4.2.баглаа боодлын жагсаалт;

3.4.3.шаардлагатай бол эрх бүхий байгууллагын зөвшөөрөл.

3.5.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх 841 кодоор бүрдүүлэлт хийсэн бараанд эхний бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага ачааны манифестад “Гаалийн хяналтад байгаа” гэсэн хяналтын тэмдэг дарж, эцсийн бүрдүүлэлт хийж байгаа хилийн гаалийн байгууллага “Монголын гааль зөвшөөрөв” гэсэн хяналтын тэмдэг дарж, хувийн дугаар бүхий тэмдгээр баталгаажуулан, мэдээллийн сүлжээнд гаалийн улсын байцаагчийн хувийн дугаарыг оруулан тухайн бичлэгт хаалт хийж гаалийн хилээр гаргана.

### **Дөрөв. Горимын шаардлага**

4.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг гаалийн удирдах төв байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага тээвэрлэнэ.

4.2.Гаалийн удирдах төв байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь барааг олон улсын тээврийн маршрутаар, гаалийн замаар гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд тээвэрлэнэ.

4.3.Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь Гаалийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан үргийг биелүүлнэ.

4.4. Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараа дараахь шаардлагыг хангасан байна:

4.4.1.гаалийн байгууллага тухайн бараанд хяналт тавих боломжтой байх;

4.4.2.гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой байх;

4.4.3.бараа нь хадгалалт тээвэрлэлтийн үед гарах стандартаар тогтоогдсон элэгдэл хорогдолоос өөр өөрчлөлтгүй анхны байдлаараа байх.

4.5.Тэсэрч дэлбэрэх, аюултай болон химиийн онцгой хортой бодис зэрэг тээвэрлэлт, хадгалалтын онцгой нэхцэл шаардах барааг дамжуулан өнгөрүүлэхэд холбогдох байгууллагын зөвшөөрөл шаардана.

4.6.Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэхэд гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.

4.7.Шаардлагатай тохиолдолд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар төлөх баталгааг тээвэрлэгч аж хуйн нэгжээс гаргуулан авна.

### **Тав. Горим дуусгавар болох**

5.1.Барааг улсын хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар улс хооронд дамжин өнгөрүүлэх горим дуусгавар болно.

Улсын гаалийн өрөнхий газрын даргын  
2008 оны 679 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

## БАРААГ ДОТООДОД ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 188-196 дугаар зүйл/-ыг хэрэгжүүлэхэд Монгол улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.
- 1.2. Энэ журмаар горимыг сонгох, барааг горимд байршуулах, бичиг баримтыг бүрдүүлэх, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.
- 1.4. Мэдүүлэгч барааг Гаалийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан хугацаанд мэдүүлэх бөгөөд мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн ачааны манифест, мэдээлэл, бичиг баримтад энэ хугацаа мөн адил хамаарна.
- 1.5. Гаалийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан ачааны манифест, барааны дагалдах бичиг баримтыг хүлээн авч бүртгэнээр барааг гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцно.
- 1.6. Улсын хилээр оруулахыг хориглосон барааг энэ горимд байршуулахгүй.

### Хоёр. Горимын код

- 2.1. Горимд нэг гаалийн байгууллагын хяналтаас нөгөө гаалийн байгууллагын хяналтад шилжүүлэх барааг байршуулна.
- 2.2. Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэхэд уг бараа нь хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.
- 2.3. Дамжуулан өнгөрүүлэхэд дараахь кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код
1	Хилийн гаалийн хяналтын бүсээс гүний гаалийн хяналтын бүсэд дамжуулан өнгөрүүлэх	842
2	Гүний гаалийн хяналтын бүсээс гүний гаалийн хяналтын бүсэд дамжуулан өнгөрүүлэх	843
3	Гүний гаалийн хяналтын бүсээс хилийн гаалийн хяналтын бүсэд дамжуулан өнгөрүүлэх	844
4	Хилийн гаалийн хяналтын бүсээс хилийн гаалийн хяналтын бүсэд дамжуулан өнгөрүүлэх	845

### Гурав. Бичиг баримт

- 3.1. Хилийн гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллагад төмөр замаар хүргэх барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулахад төмөр замын ачааны манифестийг үндэслэнэ.
- 3.2. Хилийн гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллагад авто тээврийн хэрэгслээр хүргэх барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулахад автотээврийн хэрэгслийн ачааны манифестийг үндэслэнэ.

3.3. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд тээвэрлэгч байгууллага Гаалийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан бичиг баримтаас гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

- 3.3.1.ачааны манифест;
- 3.3.2.тээврийн бичиг баримт;
- 3.3.3.худалдааны бичиг баримт;
- 3.3.4.бусад дагалдах бичиг баримт.

3.4.Дамжуулан өнгөрүүлэх 842-845 кодтой ачааны манифестэд гаалийн эхний байгууллага “Гаалийн хяналтад байгаа” гэсэн хяналтын тэмдэг дарж, нөгөө гаалийн байгууллагын хяналтад илгээнэ.

### **Дөрөв. Горимын шаардлага**

4.1.Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг гаалийн удирдах төв байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага тээвэрлэнэ.

4.2.Гаалийн удирдах төв байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь барааг гаалийн замаар гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд тээвэрлэнэ.

4.3.Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь Гаалийн тухай хуулийн 38 дугаар зүйл заасан үргийг биелүүлнэ.

4.4.Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараа доорхи шаардлагыг хангасан байна:

4.4.1.гаалийн байгууллага тухайн бараанд хяналт тавих боломжтой байх;

4.4.3.бараа нь хадгалалт тээвэрлэлтийн үед гарсан стандартаар тогтоогдсон элэгдэл хорогдолоос өөр өөрчлөлтгүй анхны байдлаараа байх.

4.5.Барааг дамжуулан өнгөрүүлэхэд гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.

4.6.Тэсэрч дэлбэрэх, аюултай болон химиин онцгой хортой бодис зэрэг тээвэрлэлт, хадгалалтын онцгой нэхцэл шаардах барааг дамжуулан өнгөрүүлэхэд холбогдох байгууллагын зөвшөөрөл шаардана.

4.7.Шаардлагатай тохиолдолд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын хуульд заасны дагуу тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авна.

### **Тав. Горим дуусгавар болох**

5.1.Барааг Монгол Улсын хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дотоодод дамжуулан өнгөрүүлэх горим дуусгавар болно.

Улсын гаалийн өрөнхий газрын даргын 2008 оны  
679 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

## БАРААГ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1.Барааг шилжүүлэн ачих гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 197-201 дугаар зүйл/-ыг хэрэгжүүлэхэд Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, Гаалийн тухай хууль, тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.
- 1.2.Энэ журмаар барааг шилжүүлэн ачих гаалийн бүрдүүлэлтийн горимтой холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.3.Горимыг мэдүүлэгч өөрөө сонгох бөгөөд горимын нэхцэл шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.
- 1.4.Мэдүүлэгч барааг Гаалийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан хугацаанд мэдүүлэх бөгөөд мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн гаалийн мэдүүлэг, мэдээлэл, бичиг баримтад энэ хугацаа мөн адил хамаарна.
- 1.5.Гаалийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан ачааны манифест, барааны дагалдах бичиг баримтыг хүлээн авч бүртгэнээр барааг гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцно.
- 1.6.Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг энэ горимд байршуулахгүй.

### Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

- 2.1.Энэ горимд хилээр оруулсан тээврийн хэрэгслээс гарах тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачиж гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулалгүйгээр хилийн чанадад гаргах гадаадын бараа хамаарна.
- 2.2.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэхэд дараахь кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код
1	Барааг шилжүүлэн ачих горим	900

### Гурав. Бичиг баримт

- 3.1.Мэдүүлэгч гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд гаалийн байгууллагад гаргаж өгнө.
- 3.2.Мэдүүлэгч барааг шилжүүлэн ачих горимоор гаалийн бүрдүүлэлт хийхэд дараахь бичиг баримтыг эх, эсхүл хуулбар хувиар гаалийн байгууллагад гаргаж өгнө:
  - 3.2.1.хилээр орсон тээврийн баримт;
  - 3.2.2.хилээр гарах тээврийн баримт;
  - 3.2.3.манифест;
  - 3.2.4.худалдааны бичиг баримт.
- 3.3.Мэдүүлэгч 3.2-т заасан бичиг баримтыг элэектрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад хүргүүлж болно.
- 3.4.Гаалийн байгууллага шаардлагатай гэж үзсэн тохиолдолд 3.2, 3.3-т заасан бичиг баримтыг түүний эх хувьтай тулган шалгана.

3.5.Журмын 3.2-т заасны дагуу авсан мэдээлэл, баримт бичиг нь шаардлага хангахгүй байвал гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ мэдүүлээгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд барааг байршуулахаас татгалзана.

3.6.Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийсэн хилийн гаалийн байгууллага гаалийн мэдүүлэгт “Гаалийн хяналтад байгаа” гэсэн хяналтын тэмдэг, тээврийн баримтанд “Монголын гааль зөвшөөрөв” гэсэн хяналтын тэмдэг дарна.

### **Дөрөв. Горимын шаардлага**

4.1.Барааг гаалийн хилээр оруулж ирсэн нэг тээврийн хэрэгслээс гарах нөгөө тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачихдаа уг барааг гаалийн хяналтын бүсэд ирснээс хойш ажлын 3 өдөрт багтааж гүйцэтгэнэ.

4.2.Барааг шилжүүлэн ачих үйл ажиллагаа нь зөвхөн нэг хилийн гаалийн байгууллагын хүрээнд явагдах бөгөөд, өөр гаалийн байгууллагаар дамжуулан хилээр гаргах бол улс хоорондын дамжуулан өнгөрөх горимоор бүрдүүлэлт хийнэ.

4.3.Бараанд шилжүүлэн ачих горимоор гаалийн бүрдүүлэлт хийлгэх ажлыг тээврийн байгууллага хариуцан гүйцэтгэж болно.

4.4.Тээврийн хэрэгслээс буулгаж гаалийн баталгаат бус, чөлөөт бүсэд оруулсан бараа энэ журамд хамаарахгүй.

4.5.Энэ горимоор бүрдүүлэлт хийх бараа нь гаалийн хилээр орсон үеэс буцаж гарах хүртэл бүхий л хугацаанд гаалийн хяналтанд байна.

4.6.Барааг шилжүүлэн ачихад гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.

4.7.Шаардлагатай бол гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар төлөх баталгааг мэдүүлэгчээс гаргуулан авч болно.

### **Тав. Горим дуусгавар болох**

5.1.Барааг улсын хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар шилжүүлэн ачих горим дуусгавар болно.